ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бигэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2025/082/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа<br>Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 99175677 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn<br>Ариун төгс оршихуй аудит ХХК-ийн Ахлах аудитор: Г.Баялаг<br>Утас: 89023656 Цахим хаяг: ariuntugsorshihuiaudit@gmail.com<br>Аудитор: С.Санчирмаа<br>УУтас: 99282488 Цахим хаяг:Sanchirmaa@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02. 23 № 80

танай ____________ -ны № ____________ -т

БИГЭР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Т.МЭНДСАЙХАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бигэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааварын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монголын цахилгаан холбоо ХХК-иас 36,141.0 мянган төгрөгөөр утасгүй дотоод сүлжээ байгуулах ажил хийгджээ.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын А/80 дугаар тушаалын дагуу математик, англи хэлний цахим сургалтын хөтөлбөр хэрэгжиж гэрээний дагуу патентын эрхийн төлбөр болох 4,965.3 мянган төгрөгийг шилжүүлж шууд зардлаар тайлагнасан байна.

8225020201

**Бусад асуудал**

Боловсролын газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 6 зорилт 56 арга хэмжээний хэрэгжилт 85.0 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **210,661,987.70** | **281,493,772.47** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **118,066,904.32** | **180,931,164.49** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **118,066,904.32** | **180,931,164.49** |
| **31210** | **Төгрөг** | **118,066,904.32** | **180,931,164.49** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 118,066,904.32 | 180,931,164.49 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **92,595,083.38** | **100,562,607.98** |
| **35100** | **Түүхий эд материал** | **81,777,753.38** | **89,627,730.38** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 80,592,753.38 | 88,442,730.38 |
| 35130 | Эм боох материал | 1,185,000.00 | 1,185,000.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **10,817,330.00** | **10,934,877.60** |
| 35420 | Аж ахуйн материал | 1,490,000.00 | 4,174,900.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,222,500.00 | 4,999,327.60 |
| 35450 | Барилгын засварын материал | 0.00 | 84,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,104,830.00 | 1,676,650.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,821,316,788.64** | **5,006,497,913.66** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **4,821,316,788.64** | **5,006,497,913.66** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **4,750,204,708.68** | **4,937,553,353.74** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,212,241,536.83 | 4,350,236,613.83 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (268,039,973.64) | (357,046,259.35) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 224,071,456.80 | 397,118,011.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (48,854,315.21) | (96,688,088.11) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 266,850,887.50 | 359,878,887.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (104,324,615.58) | (133,059,456.15) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 571,354,233.00 | 571,354,233.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (120,530,428.34) | (171,676,516.10) |
| 39217 | Ном | 17,435,927.32 | 17,435,927.32 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **71,112,079.96** | **68,944,559.92** |
| 39301 | Програм хангамж | 10,987,600.00 | 10,987,600.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,197,520.04) | (4,365,040.08) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 62,322,000.00 | 62,322,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,031,978,776.34** | **5,287,991,686.13** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,540,000.00** | **36,141,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **1,540,000.00** | **36,141,000.00** |
| **41300** | **Өглөг** | **1,540,000.00** | **36,141,000.00** |
| **41360** | **Бусад өглөг** | **1,540,000.00** | **36,141,000.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,540,000.00 | 36,141,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,030,438,776.34** | **5,251,850,686.13** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **5,030,438,776.34** | **5,251,850,686.13** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 511,201,648.27 | 511,201,648.27 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 511,201,648.27 | 511,201,648.27 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **3,767,558,733.52** | **3,988,970,643.31** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,758,387,608.21 | 3,767,419,561.12 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 9,171,125.31 | 221,551,082.19 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 751,678,394.55 | 751,678,394.55 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,031,978,776.34** | **5,287,991,686.13** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,548,662,138.98** | **2,266,142,952.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **125,114,041.10** | **373,433,952.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **125,114,041.10** | **373,433,952.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **83,288,112.00** | **40,691,600.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,084,200.00 | 0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,110,000.00 | 40,691,600.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 80,093,912.00 | 0 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 32,569,060.00 | 309,838,832.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 9,256,869.10 | 22,903,520.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,423,548,097.88** | **1,892,709,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,370,081,100.00** | **1,892,709,000.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,370,081,100.00 | 1,892,709,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **53,466,997.88** | **0** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 53,466,997.88 | 0 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,539,491,013.67** | **2,044,591,869.81** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,539,491,013.67** | **2,044,591,869.81** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,499,197,833.67** | **2,008,750,369.81** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **988,887,401.07** | **1,468,781,621.00** |
| 210101 | Үндсэн цалин | 655,316,953.12 | 855,736,812.00 |
| 210102 | Нэмэгдэл | 285,805,323.95 | 560,678,041.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0 | 0 |
| 210104 | Урамшуулал | 47,765,124.00 | 52,366,768.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **124,730,928.17** | **179,983,052.99** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 85,500,733.95 | 122,987,618.78 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,018,172.11 | 14,697,424.03 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,015,097.63 | 7,461,184.43 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,926,905.14 | 7,072,926.06 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,270,019.34 | 27,763,899.69 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **59,807,497.88** | **0** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,440,887.88 | 0 |
| 210302 | Түлш, халаалт | 43,996,350.00 | 0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 370,260.00 | 0 |
| **2105** | **Норматив зардал** | **59,100,620.00** | **47,319,654.50** |
| 210502 | Хоол, хүнс | 59,100,620.00 | 47,319,654.50 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,004,000.00** | **0** |
| 210604 | Урсгал засвар | 3,004,000.00 | 0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,966,400.00** | **21,452,901.34** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,084,200.00 | 4,366,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,882,200.00 | 17,086,301.34 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **254,700,986.55** | **291,213,139.98** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,456,995.00 | 49,133,633.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,311,000.00 | 5,646,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 224,932,991.55 | 236,433,506.98 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **40,293,180.00** | **35,841,500.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **40,293,180.00** | **35,841,500.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 40,293,180.00 | 35,841,500.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **9,171,125.31** | **221,551,082.19** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **9,171,125.31** | **221,551,082.19** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)**

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,426,742,297.88** | **1,933,400,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,194,200.00** | **40,691,600.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **3,194,200.00** | **40,691,600.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **3,194,200.00** | **40,691,600.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,084,200.00 | 0.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,110,000.00 | 40,691,600.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,423,548,097.88** | **1,892,709,000.00** |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,370,081,100.00** | **1,892,709,000.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,370,081,100.00 | 1,892,709,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **53,466,997.88** | **0.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 53,466,997.88 | 0.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,303,399,402.12** | **1,794,901,539.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,303,399,402.12** | **1,794,901,539.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,263,106,222.12** | **1,758,921,189.83** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **988,887,401.07** | **1,468,781,621.00** |
| 210101 | Үндсэн цалин | 655,316,953.12 | 855,736,812.00 |
| 210102 | Нэмэгдэл | 285,805,323.95 | 560,678,041.00 |
| 210104 | Урамшуулал | 47,765,124.00 | 52,366,768.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **124,730,928.17** | **179,983,052.99** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 85,500,733.95 | 122,987,618.78 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,018,172.11 | 14,697,424.03 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,015,097.63 | 7,461,184.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,926,905.14 | 7,072,926.06 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,270,019.34 | 27,763,899.69 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **50,466,997.88** | **0.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,440,887.88 | 0.00 |
| 210302 | Түлш, халаалт | 33,665,850.00 | 0.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,360,260.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **56,817,500.00** | **44,752,624.50** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 0.00 | 0.00 |
| 210502 | Хоол, хүнс | 56,817,500.00 | 44,752,624.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,000,000.00** | **0.00** |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,966,400.00** | **21,452,901.34** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,084,200.00 | 4,366,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,882,200.00 | 17,086,301.34 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **30,236,995.00** | **43,950,990.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,910,995.00 | 31,511,590.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,326,000.00 | 12,439,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **40,293,180.00** | **35,980,350.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **40,293,180.00** | **35,980,350.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 40,293,180.00 | 35,980,350.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **123,342,895.76** | **138,499,060.17** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **29,794,100.00** | **75,634,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **29,794,100.00** | **75,634,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **29,794,100.00** | **75,634,800.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 29,794,100.00 | 75,634,800.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(29,794,100.00)** | **(75,634,800.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **93,548,795.76** | **62,864,260.17** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 24,518,108.56 | 118,066,904.32 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 118,066,904.32 | 180,931,164.49 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **511,201,648.27** | **751,678,394.55** | **3,758,387,608.21** | **5,021,267,651.03** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **511,201,648.27** | **751,678,394.55** | **3,758,387,608.21** | **5,021,267,651.03** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **9,171,125.31** | **9,171,125.31** |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **511,201,648.27** | **751,678,394.55** | **3,767,558,733.52** | **5,030,438,776.34** |
| **11** | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **511,201,648.27** | **751,678,394.55** | **3,767,558,733.52** | **5,030,438,776.34** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | (139,172.40) | (139,172.40) |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **511,201,648.27** | **751,678,394.55** | **3,767,419,561.12** | **5,030,299,603.94** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 221,551,082.19 | 221,551,082.19 |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-** | **511,201,648.27** | **751,678,394.55** | **3,988,970,643.31** | **5,251,850,686.13** |



ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **наарх үлдэгдэл** | | | | |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,049,826,500.00** | **1,870,536,339.83** | **179,290,160.17** | **91.3** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,049,826,500.00** | **1,870,536,339.83** | **179,290,160.17** | **91.3** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,009,140,300.00** | **1,834,555,989.83** | **174,584,310.17** | **91.3** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,581,408,600.00** | **1,468,781,621.00** | **112,626,979.00** | **92.9** |
| 210101 | Үндсэн цалин | 1,006,696,300.00 | 855,736,812.00 | **150,959,488.00** | **85.0** |
| 210102 | Нэмэгдэл | 544,018,600.00 | 560,678,041.00 | **-16,659,441.00** | **103.1** |
| 210104 | Урамшуулал | 30,693,700.00 | 52,366,768.00 | **-21,673,068.00** | **170.6** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **197,676,100.00** | **179,983,052.99** | **17,693,047.01** | **91.0** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 134,419,700.00 | 122,987,618.78 | **11,432,081.22** | **91.5** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,814,200.00 | 14,697,424.03 | **1,116,775.97** | **92.9** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,907,000.00 | 7,461,184.43 | **445,815.57** | **94.4** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,907,000.00 | 7,072,926.06 | **834,073.94** | **89.5** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,628,200.00 | 27,763,899.69 | **3,864,300.31** | **87.8** |
| **2105** | **Нормативт зардал** | **68,036,600.00** | **44,752,624.50** | **23,283,975.50** | **65.8** |
| 210502 | Хоол, хүнс | 68,036,600.00 | 44,752,624.50 | **23,283,975.50** | **65.8** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **31,675,400.00** | **21,452,901.34** | **10,222,498.66** | **67.7** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,366,600.00 | 4,366,600.00 | **0.00** | **100.0** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 27,308,800.00 | 17,086,301.34 | **10,222,498.66** | **62.6** |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **130,343,600.00** | **119,585,790.00** | **10,757,810.00** | **91.7** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 117,901,300.00 | 107,146,390.00 | **10,754,910.00** | **90.9** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,442,300.00 | 12,439,400.00 | **2,900.00** | **100.0** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **40,686,200.00** | **35,980,350.00** | **4,705,850.00** | **88.4** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **40,686,200.00** | **35,980,350.00** | **4,705,850.00** | **88.4** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 40,686,200.00 | 35,980,350.00 | **4,705,850.00** | **88.4** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,049,826,500.00** | **1,933,400,600.00** | **116,425,900.00** | **94.3** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,892,709,000.00** | **1,892,709,000.00** | **0.00** | **100.0** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,892,709,000.00 | 1,892,709,000.00 | **0.00** | **100.0** |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **157,117,500.00** | **40,691,600.00** | **116,425,900.00** | **25.9** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,366,600.00 | 0 | **4,366,600.00** | **-** |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 34,425,000.00 | 40,691,600.00 | **-6,266,600.00** | **118.2** |
| **350003** | **Урьд оны үлдэгдлээс санхүүжих** | **118,325,900.00** | **0** | **118,325,900.00** | **-** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**3.1** Аудитаар 56.0 мянган төгрөгийн алдаа[1]-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Эдийн засгийн ангилал зөрчиж ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлээс 56.0 мянган төгрөгийн албан томилолтод зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн.

Залруулагдаагүй нийт 9,661.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 9,661.8 мянган төгрөгийн 5 зөрчил[2] илэрсэнд 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага,2 зөвлөмж хүргүүлсэн.

**3.2 Төлбөрийн акт**

1. Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулсан , цалингийн урьдчилгаа суутгаагүй 597.8 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.3 Албан шаардлага**

1. Хамаарал бүхий этгээдийн дансаар дамжуулан 672.5 мянга төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасантай, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Хамаарал бүхий этгээдийн худалдан авалт хийсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

2. Санхүүгийн ажилтанд хууль тогтоомжид зааснаас 735.5 мянган төгрөгөөр илүү шагнал, урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Хууль тогтоомжид заасан хувь хэмжээнээс хэтрүүлж шагнал, урамшуулал олгосон зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

---

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Бүртгэл тайлагналтай холбоотой асуудал***

*Илрүүлэлт-1:*
Эдийн засгийн ангилал зөрчиж ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 3,985.1 мянган төгрөгийн даатгуулагчийн шимтгэлийг төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

*Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулж байх.

*Илрүүлэлт-2*
Ажиллагсдын цалинг Нийгмийн даатгалын хэлтэс болон Татварын газарт 3,670.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"; Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 хуулийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх"; Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т "суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах"; нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Нийгмийн даатгалын болон Татварын нөхөн тайланг гаргаж баталгаажуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.
Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл* (мянган төгрөгөөр)

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэээс: | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Бигэр сумын Ерөнхий боловсролын сургууль | Эдийн засгийн ангилал зөрчиж ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлээс 56.0 мянган төгрөгийн албан томилолтод зарцуулсан. | 1 | 56.0 | - | - | 1 | 56.0 | 1 | 56.0 | - | - | - | - |
| **Дүн** | | **1** | **56.0** | **-** | **-** | **1** | **56.0** | **1** | **56.0** | **-** | **-** | **-** | **-** |

*4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Бигэр сумын Ерөнхий боловсролын сургууль | Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулсан , цалингийн урьдчилгаа суутгаагүй 597.8 мянган төгрөг. | 1 | 597.8 | 1 | 597.8 | - | - | - | - | - | - |
| | Хамаарал бүхий этгээдийн дансаар дамжуулан 672.5 мянга төгрөгийн гүйлгээ хийсэн. | 1 | 672.5 | - | - | 1 | 672.5 | - | - | 1 | 597.8 |
| | Санхүүгийн ажилтанд хууль тогтоомжид заасанаас 735.5 мянган төгрөгөөр илүү шагнал, урамшуулал олгосон. | 1 | 735.5 | - | - | 1 | 735.5 | - | - | 1 | 597.8 |
| | Эдийн засгийн ангилал зөрчиж ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 3,985.1 мянган төгрөгийн даатгуулагчийн шимтгэлийг төлсөн. | 1 | 3,985.1 | - | - | - | - | 1 | 3,985.1 | 1 | 597.8 |
| | Ажиллагсдын цалинг Нийгмийн даатгалын хэлтэс болон Татварын газарт 3,670.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. | 1 | 3,670.9 | - | - | - | - | 1 | 3,670.9 | - | - |
| **Дүн** | | **5** | **9,661.8** | **1** | **597.8** | **2** | **1,408.0** | **2** | **7,656.0** | **-** | **-** |



Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | | **1** | | | **1** | | | |